



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and
Competitiveness Project

ЭЗБШӨЧ төслийн сар тутмын цуврал

2007 оны 9 дүгээр сар

Худалдаа, тээврийг хөнгөвчлөх Үндэсний хороо техникийн уулзалт зохион байгуулав

Энэ оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо Зам, тээвэр, аялал жуулчлалын яаман (ЗТАЖЯ) дээр техникийн уулзалт зохион байгуулж, хувийн хэвшлийн төлөөлөгчид болох тээвэр зуучийн компаниуд, Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын (ҮХАҮТ) хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, хөтөлбөрт төрийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх асуудлын талаар ярилцав.

Уулзалтад дараах төлөөлөгчид оролцсон болно. Үүнд:



- ЗТАЖЯ-ны Тээврийн газрын дарга Д.Наранпүрэв
- ЗТАЖЯ-ны Тээврийн газрын мэргэжилтэн, Үндэсний Хорооны нарийн бичгийн дарга Ё. Жаргалсайхан
- ҮГЕГ-ын Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга, Цахим нэг цонхны ажлын хэсгийн нарийн бичгийн дарга С.Алтангэрэл
- ҮГЕГ-ын Гаалийн хяналтын хэлтсийн дарга Б.Лхагвадорж
- МХХТГ-ын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Нямхүү
- ҮХЯ-ны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн З. Чинбазар
- Төмөр замын зохицуулах газар (ТЗЗГ)-ын хуулийн мэргэжилтэн С.Оюунбат
- ТЗЗГ-ын Тээврийн үйлчилгээний мэргэжилтэн С.Ариунсайхан
- Улаабаатар хотын төмөр замын хэрэг эрхлэх газар (УБТЗХЭГ)-ын Хүний нөөц, нийгмийн асуудал хариуцсан дэд дарга Л. Халтар
- УБ хотын гаалийн газрын Гаалийн хяналтын газрын дарга Ж. Гантүг

- Чингис Хаан нисэх онгоцны буудлын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Л. Ганцэцэг
- Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын ахлах мэргэжилтэн А. Батсуурь
- Туушин ХХК-ий дэд захирал Б. Пүрэвчулуун
- Олон улсын тээвэр зуучийн төвийн Ерөнхий захирал П.Батхуяг
- Эрин Интернейшнал ХХК-ий захирал Я. Эрхэмбаяр
- Трансгейт ХХК-ий гүйцэтгэх захирал Д.Энхээ
- Монгол Экспресс ХХК-ий Бизнесийн хөгжлийн менежер Б. Батхүү
- ҮХАҮТ-ын Бизнес, хөрөнгө оруулалтыг дэмжих төвийн дарга Ж.Оюунчимэг
- Шинжлэх ухаан, технологийн үйлдвэрлэл, электротехник, машин судлалын нэгдлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Ёндонсүрэн
- ШУТИС-ийн судлаач А. Мөнхболд

Уулзалтын гол зорилгыг дор дурдав. Үүнд:

- Худалдааг хөнгөвчлөх Цахим нэг цонх (ЦНЦ) болон Транзит Монгол үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцыг танилцуулах
- Дээрх хөтөлбөрүүдэд оролцогч байгууллагуудын өнөөгийн байдлын талаар танилцуулах
- Эдгээр хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг зангидаж, уялдуулан зохицуулах, үйл ажиллагааны давхардлаас зайлсхийх үүднээс Худалдааг хөнгөвчлөх нэгдсэн хүрээг бий болгох
- Эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд нэн түрүүнд гүйцэтгэх богино хугацааны үйл ажиллагааг тодорхойлж, харилцан тохиролцох.

ҮГЕГ-ын Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга С. Алтангэрэл ЦНЦ хөтөлбөрийн гол үзэл баримтлал, гаалийн гүйцэтгэх үүрэг, хувийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих улсын ба хувийн хэвшлийн түншлэл бүхий бие даасан компанийг байгуулах гэсэн хөтөлбөрийн гол зорилтуудын талаар танилцуулав. ЗТАЖЯ-ны ахлах мэргэжилтэн Ё. Жаргалсайхан Транзит Монгол үндэсний хөтөлбөрийн төслийн агуулгын талаар танилцуулж, төрийн байгууллагууд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх өөрсдийн үүргийн талаар мэдээлэл хийж, тээвэр зуучийн компаниуд хоёр хөтөлбөрийн талаар өөрсдийн санал бодлыг илэрхийллээ.

Ялангуяа УБ хотын Төмөр замын хэрэг эрхлэх газрын Хүний нөөц, нийгмийн асуудал хариуцсан дэд дарга Л. Халтар, ТЗЗГ-ын мэргэжилтэн С. Ариунсайхан нарын төмөр замын өнөөгийн нөхцөл байдал, Төмөр замын тээврийн тухай шинэ хуулийн хэрэгжилтийн явцын талаар презентаци тавьсан нь цаг үеэ олсон чухал сэдэв байв. Илтгэгчид байгууллагуудынхаа нэрийн өмнөөс ложистикийн төвийг байгуулах, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн хэсгийг сайжруулахад их хэмжээний хөрөнгө оруулалт нэн даруй шаардлагатай буйг цохон тэмдэглээд, энэ үйл хэргийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахад бэлэн байгаагаа илэрхийлэв.

Үүний хариуд тээвэр, зуучийн байгууллагууд Улаанбаатар, Замын-Үүдэд ложистикийн орчин үеийн үйлчилгээг бий болгох, хөдлөх бүрэлдэхүүн хэсгийг сайжруулахад хөрөнгө оруулалт хийхэд бэлэн буйгаа мэдэгдэв. Улаанбаатар хотыг бүсчлэж, ангиллыг дахин хийх боломжийн талаар шийдвэр гаргах явц удаан байгаад санаа зовниж буйгаа хувийн компаниуд илэрхийлжээ. Хотын орчимд төмөр замын дагуу ложистик үйлчилгээний төвүүдийг бий болгох асуудал тодорхой болсон нөхцөлд хөрөнгө оруулалт хийх бололцоотой талаар тээвэр зуучийн компаниуд ярилцав.

Ложистикийн төвүүдийн байршлын асуудалд нөлөөлөх Улаанбаатар хотыг бүсчлэх асуудлыг түргэвчлэх талаар Улаанбаатар хотын захиргаатай ярилцаж, энэ талаарх шийдвэрийг ил тод байдлаар хувийн хэвшлийнхэнтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр аль болох түргэн гаргах нь зүйтэй гэдэг дээр уулзалтад оролцогчид санал нэгдэв. Мөн хотын захиргаа болон хувийн хэвшлийнхний хооронд хийх энэхүү ярилцлагыг зохион байгуулах ажлыг ЭЗБШӨЧ төслийнхэн удирдан хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг мөн санал нэгтэй дэмжив.

Улаанбаатар хотын орчим төмөр замын дагуу байгуулах цэгүүд ложистикийн төвүүдийн байршилд хэрхэн нөлөөлж болох талаар тээвэр зуучийн компаниуд, УБТЗХЭГ ба ТЗЗГ хамтран ярилцах арга хэмжээг зохион байгуулах асуудлыг ҮХАҮТ-ын дэргэдэх Ложистикийн хорооны дарга Л. Халтар хариуцахаар болов.

Тээвэр зуучийн компаниуд хот орчим төмөр замын дагуу ложистикийн төвүүд байгуулж, Улаанбаатар хотыг бүсчлэх асуудлаар шийдвэр гаргахад тэдний оролцоо ямар байх талаар хотын захиргаа, УБТЗХЭГ, ТЗЗГ-тай хамтран ярилцах уулзалтыг 10 дугаар сарын эхээр хийхийг санал болгов. Эдгээр асуудлууд тодорхой болмогц ложистикийн төв байгуулахад хөрөнгө оруулалт хийхэд бэлэн байна гэдгээ тээвэр зуучийн компаниуд илэрхийлэв.

Монголын Ипотекийн корпорацийн хувь нийлүүлэгчид тус корпорацийн хөрөнгийг нэмэгдүүлэв

Монголын Ипотекийн корпораци (МИК)-ийн Удирдах зөвлөлийн дарга тус корпорацийн хөрөнгийг 2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан хувь нийлүүлэгчдэд гэрчилгээ гардуулах ёслолын арга хэмжээг 9 дүгээр сарын 4-ний өдөр зохион байгуулав. Хөрөнгийг нэмэгдүүлсэнээр МИК мортгейж худалдан авах, "зээлийн баталгаат агуулах" бүрдүүлэх боломжтой болох юм.



Энэхүү арга хэмжээнд Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, Сангийн яамны Санхүүгийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х. Рагчаа болон МИК-ийн хувь нийлүүлэгч банкуудын гүйцэтгэх захирлууд оролцов.

Барилга, хот байгуулалтын сайд Ж. Наранцацралт хэлсэн үгэндээ Монголын хөрөнгийн зах зээл хөгжлийнхээ эхэн шатанд байгааг тэмдэглээд мортгейжээр баталгаажсан үнэт цаасыг гаргах байдлаар хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжлийг МИК тэргүүлж буй тухай цохон дурьдлаа. "Хэрэв мортгейжийн үнэт цаасжуулалт амжилттай хэрэгжиж, зөв замаар хөгжвөл энэ нь хүн амыг орон сууцаар хангах асуудалд чухал нөлөө үзүүлж, бага орлоготой өрхүүдэд орон сууцтай болоход нь бага хүүтэй, урт хугацааны зээл олгох боломж бүрдэх юм" гэж тэрээр хэлээд МИК-ийн цаашдын хөгжилд Барилга, хот байгуулалтын яам тууштай дэмжлэг үзүүлэхээ мэдэгдэв.

Үндэсний аялал жуулчлалын байгууллага стратегийн төлөвлөлтийн талаар сургалт зохион байгуулав

Үндэсний аялал жуулчлалын байгууллагын (ҮАЖБ) удирдах зөвлөл хэд хэдэн удаа уулзаж ярилцсаны эцэст 2008-2011 оны стратегийн төлөвлөгөөг боловсруулах нэг өдрийн сургалтыг 9 дүгээр сарын 19-нд зохион байгуулав. ЭЗБШӨЧ төслийн шугамаар ирсэн олон улсын зөвлөх Доктор Ханна Мессерли, ноён Жереми Кондор нар 10 хоногийн туршид тус байгууллагад зөвлөгөө өгч ажиллалаа. Доктор Х.Мессерли аялал жуулчлалын, ноён Ж.Кондор байгууллагын хөгжлийн чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүд юм.

ҮАЖБ-ын 2008-2011 оны бодит, хэрэгжэхүйц стратегийн төлөвлөгөөг боловсруулахад сургалтын зорилго оршиж байв. Энэхүү сургалтад Монголын Зочид буудлын холбоо, Аялал жуулчлалын мэдээллийн төв, Хөтөч-тайлбарлагчдын холбоо, Жуулчны баазуудын холбоо, Баттур компанийн төлөөлөгчид, ҮАЖБ-ын гүйцэтгэх захирал болон зарим хувь хүмүүс оролцлоо.

Удирдах зөвлөлийн гишүүд зөвлөхүүдийн туслалцаа дэмжлэгтэйгээр Монголын аялал жуулчлалын салбарын хөгжил, чиг хандлагад нарийвчилсан дүн шинжилгээ хийж, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс, энэ талаар гаргасан саналуудыг ҮАЖБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа анхааран үзэхээр болов. Үүнээс гадна сургалтад оролцогсод аялал жуулчлалын салбарт ҮАЖБ-ын гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь,



санхүүжилтийн янз бүрийн эх үүсвэр болон эхний 6-12 сарын хугацаанд нэн түрүүнд гүйцэтгэх ажлуудад анхаарлаа хандуулав.

Зөвлөхүүдийн гаргасан тайланг ҮАЖБ-ын удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэхээр ЭЗБШӨЧ төсөл орчуулж байна. Монголыг зорих газрын хувьд таниулан сурталчлах, "олон улсын зах зээл дээр нэг дуу хоолойтой байх" үүднээс салбарын төлөвлөгөөг боловсруулж санал болгох, ҮАЖБ-ыг нийт салбарын хэмжээнд танилцуулах арга хэмжээг 11 дүгээр сард зохион байгуулахаар тус байгууллагын удирдах зөвлөл төлөвлөж байна.

ҮАЖБ нь шинэ байгууллагын хувьд аль болох түргэн хугацаанд зах зээл дээр өөрийн байр суурийг эзлэж, албан ёсоор салбарын дуу хоолой болж, салбартаа хүлээн



зөвшөөрөгдөхийн тулд мэдрэгдэхүйц ажлуудыг хийх шаардлагатай гэдгийг 9 дүгээр сарын 25-нд албан ёсоор бүртгүүлж тамгаа авсан ҮАЖБ-ын удирдах зөвлөлийн гишүүд маш сайн ойлгож байгаа билээ.

Сурвалжлагчид Шарын голын уурхайтай танилцав

8 дугаар сарын 30-нд сонин, радио, телевизийн 8 сурвалжлагч Шарын голын нүүрсний уурхайд зочилсноор уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь танилцан, эрчим хүчний үйлдвэрлэлд нүүрсний үзүүлдэг үр нөлөөллийн талаар мэдээлэх авлаа. Энэхүү арга хэмжээг Түлш, эрчим хүчний яам, Сангийн яам, Төрийн өмчийн хороо болон Эрчим хүчний зохицуулах газраас хамтран санаачилсан эрчим хүчний асуудлаарх олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлын хүрээнд зохион байгуулсан бөгөөд Хэвлэлийн хүрээлэн ба тус төслөөс дэмжлэг үзүүлсэн болно.

Шарын гол орох замд сэтгүүлчдэд Монгол улсын эрчим хүчний салбарын талаар болон эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглэгчдэд нүүрс, нүүрсний үнийн өөрчлөлт хэрхэн нөлөөлдөг тухай танилцуулга хийлээ. Сэтгүүлчид уурхайчдын цайны газарт тэдний өдөр тутам иддэг үдийн хоолыг идэх зуураа уурхайн удирдлагуудтай ярилцснаас гадна уурхайн нөхцөл байдалтай биечлэн танилцаж, уурхайчдад тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудын талаар ярилцаж, санхүү хариуцсан мэргэжилтнээс санхүүгийн нөхцөл байдлын талаар нарийвчлан тодруулав.

Энэхүү арга хэмжээний талаар сонин хэвлэлээр доорхи байдлаар мэдээлсэн байна. Үүнд:

- "Өдрийн сонин"-ы эхний нүүрт хоёр нийтлэл хэвлэгдсэн: эхний нийтлэлд (зурагтай) уурхайн үйл ажиллагааг танилцуулж, хоёр дах нийтлэлд үйлдвэрлэлийн зардлаас доогуур тогтоосон нүүрсний үнийг эсэргүйцэж ажил хаях гэж буй талаар мэдээлсэн байв.
- 21 аймагт уншигчтай МОНЦАМЭ Мэдээ сонинд нилээд дэлгэрэнгүй нийтлэл 3 зургийн хамт хэвлэгдсэн.
- МҮОНТ-ээр 2 нэвтрүүлэг цацсанаас гадна мөн ТВ-5-аар богино хэмжээний мэдээ дамжуулжээ.

Эрчим хүчний асуудлаар олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажил сонин хэвлэлийн сэтгүүлч сурвалжлагчид зориулсан 2 сургалтыг зохион байгуулснаар эхэлсэн билээ. Эхний сургалтыг 6 дугаар сарын 12-нд, хоёр дахь сургалтыг 7 дугаар сарын эхээр зохион байгуулснаас гадна ЭХЗГ-аас 8 дугаар сарын 10-нд Улаанбаатар хотын ДЦС 3-тай сэтгүүлчдийг биечлэн танилцуулах аялал хийсэн.

Шарын голын уурхайд сэтгүүлчдийн хийсэн аялал нь өвлийн халаалтын улирал эхлэж буйтай холбогдуулан эрчим хүч үйлдвэрлэлийг нүүрсээр хангах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй уурхайчдын ажил хаялтын өмнө болсноороо цаг үеэ олсон чухал арга хэмжээ боллоо. Нүүрсийг худалдан авах зардал нь эрчим хүч үйлдвэрлэлтийн зардлын 56%-ийг эзлэдэг тухай мэдээллийг сурвалжлагчид авч, нүүрсний үнэ цахилгаан станцуудын санхүүгийн тогтвортой байдалд шууд нөлөө үзүүлдэг талаар ойлголтоо болов.

Нүүрсний үнийг нүүрсний үйлдвэрлэлийн зардлаас доогуур тогтоох нь эрчим хүчний салбарын санхүүгийн дампуурлыг далдлах арга хэмжээ биш гэдгийг сурвалжлагчид ойлгож авлаа. Харин эрчим хүчний салбарт дараах арга хэмжээг авах нь зүйтэй. Үүнд:

- Цаашид өдөр ирэх тутам өсч буй цахилгаан эрчим хүч, дулааны хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд хуучирсан ДЦС 3-ын хүчин чадлыг сэлбэх, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд яаралтай хөрөнгө оруулалт хийх
- Үнэ тарифийг үйлдвэрлэлийн зардлыг нөхөж чадах хэмжээнд тогтоодог байх
- Ядуу ба орлого багатай хэрэглэгчдэд зориулсан тариф тогтоох, татаас олгох ил тод тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх
- Салбарын үр ашигтай үйл ажиллагааны өнөөгийн бүрхэг байдлыг сайжруулахын тулд хэрэгжүүлэх хугацааг нарийн заасан, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах
- Экспортод гаргах эрчим хүчийг үйлдвэрлэх нүүрсний уурхайн шинэ орд, цахилгаан станцуудыг уурхайг түшиглэн байгуулах, ажлын байрыг бий болгосноор орлогыг нэмэгдүүлэх, нэмэгдсэн өртөг бүхий уурхайн боловсруулалтын үйл ажиллагааг дэмжих нүүрсний салбарын ил тод стратегийг боловсруулах

Шарын голын уурхайд хийсэн аялал нь Засгийн газраас санаачилсан олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлын хүрээнд авч буй арга хэмжээнүүдийн нэг байснаас гадна эрчим хүчний салбарт удаан хугацааны туршид тулгарч буй асуудлыг хэлэлцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, Монгол улсын нүүрсний баялаг нөөцийг эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд ашиглахад чухал ач холбогдол бүхий арга хэмжээ болов.



Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилгоор Үндэсний Татварын алба өөрийн вэбсайтыг өөрчлөн шинэчиллээ

Өнгөрсөн 5 дугаар сард Татварын долоо хоногийн үеэр туршилтын журмаар хийсэн вэбсайтаа Үндэсний Татварын ерөнхий газар өөрчлөн шинэчлэж, 9 дүгээр сард албан ёсоор нээлээ. Энэхүү вэбсайтыг (www.mta.mn) тус төслийн туслалцаатайгаар, чөлөөт эхтэй агуулгын удирдлагын систем болох Joomla!Mongolia ашиглан, 2007 оны 6 дугаар сард МХХТГ-аар дамжуулан туршилтын журмаар байгуулсан болно.

Үндэсний Татварын албаны (ҮТА) вэбсайт татварын хуультай холбоотой мэдээлэл, татварын маягтууд, дүрэм журам, ҮТА-ны бүх салбаруудын мэргэжилтнүүдийн холбоо барих утас, асуулт-хариулт, татварын үйл явдал гэсэн хэд хэдэн хэсэгтэйгээс гадна хувь хүний орлогын албан татварыг тооцох тооны машиныг байрлуулсанаараа орчин үеийн, хэрэглэгчдэд таатай вэбсайт болж чадсан байна. Доорхи зурагт вэбсайтын нүүр хуудас, хувь хүний орлогын албан татварыг тооцох тооны машиныг харуулсан болно.



Вэбсайт нь хэрэглэгчдэд чиглэсэн байгууллага болох, татварын маягтуудыг бөглөх, татварын тайлан гаргах асуудлыг татвар төлөгчдөд хялбар болгоход чиглэсэн ҮТА-ны хүчин чармайлтын нэг илрэл юм. Жишээлбэл, НӨАТ-ыг буцаан олгох ажлыг анх удаа цахим хэлбэрээр хийх боломжтой болсон бөгөөд одоогийн байдлаар ҮТА 3,000 гаруй НӨАТ-ыг буцаан олгох өргөдлийг хүлээн аваад байна. Улаанбаатар, Дархан хотуудад татвар төлөгчдөд тус дөхөм болох нэг цэгийн үйлчилгээ хэрэгжиж эхлээд байгаа бөгөөд бусад аймгуудад ч мөн шуурхай өргөн хэрэгжиж байна. Уг төслөөс вэбсайтыг монгол хэл дээр гаргаж, татварыг буцаан олгох маягтуудыг боловсруулахад дэмжлэг үзүүлснээс гадна цаашид гадаадын хөрөнгө оруулагчдад туслалцаа үзүүлэх үүднээс вэбсайтыг англи хэл дээр гаргах, ҮТА-ны сүлжээний мэдээлэл, технологийг аюулгүй байдлыг хангах, олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглэгчдэд туслах төвүүдийг бий болгоход техникийн туслалцаа үзүүлсээр байх болно.



Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны тухайн сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай үүсвэрийг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтийг ЭЗБШӨЧ төслийн цувралын эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.
 И-мэйл fbertoli@epic-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.